



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/377

Хэрлэн сум

Нэр өөрчлөх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.19, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлгийн MNS 5700:2020 стандарт шинэчлэн батлагдсаны хүрээнд Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн оноосон нэрийг Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг болгон өөрчилсүгэй.

2. Бичиг баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дарга (М.Даваа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 2 дугаар сарын 28-ны А/107 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010845